



I-IX/2023

Тархаасан: 2023 оны 11 дүгээр сарын 11




## Төлбөрийн тэнцэл 2023 оны эхний 9 сард 791.4 сая америк долларын ашигтай гарлаа

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2022 оны эхний 9 сард 1.8 тэрбум америк долларын алдагдалтай байсан бол 2023 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 606.7 сая америк долларын ашигтай гарсан. Урсгал данс ашигтай гарахад барааны худалдааны экспорт нэмэгдэж, барааны худалдааны тэнцэл 3.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан нь нөлөөлсөн байна.

### ХҮСНЭГТ 1. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, сая.доллар

	Жил			Эхний 9 сар				Өөрчлөлт	
	2020	2021	2022	2020	2021	2022	2023*	Дүн	Хувь
Урсгал данс	- 675	- 2 108	- 2 303	- 733	- 1 907	- 1 790	607	2 397	-
Хөрөнгийн данс	103	114	154	76	87	106	93	- 13	- 12
Санхүүгийн данс	- 1 504	- 1 982	- 1 644	- 531	- 1 001	- 906	- 461	445	- 49
Алдаа болон орхигдуулга	- 146	- 209	- 222	- 347	239	- 581	- 369	212	- 36
Нөөц хөрөнгө	787	- 222	- 727	- 473	- 580	- 1 359	791	2 150	-

### ЗУРАГ 1. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН БҮТЭЦ, жил бүрийн эхний 9 сард, сая ам.доллар



Үйлчилгээний худалдааны тэнцэл 2023 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.9 тэрбум америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 333.2 сая ам.доллаароор өссөн байна.

Үйлчилгээний худалдааны орлого 2023 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 556.6 сая

ам.доллороор, зарлага 3.2 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс зарлага 889.9 сая ам.доллороор тус тус өссөн байна.

## ХҮСНЭГТ 2. УРСГАЛ ДАНС, сая ам.доллар

	Жил			Эхний 9 сар			Өөрчлөлт	
	2020	2021	2022	2021	2022	2023	Дүн	Хувь
<b>УРСГАЛ ДАНС</b>	<b>- 675</b>	<b>-2 108</b>	<b>-2 303</b>	<b>-1 907</b>	<b>-1 790</b>	<b>607</b>	<b>2 397</b>	<b>-</b>
<b>1. Бараа</b>	<b>1 756</b>	<b>1 370</b>	<b>1 233</b>	<b>442</b>	<b>463</b>	<b>3 375</b>	<b>2 912</b>	<b>7<sup>1</sup></b>
Экспорт	6 991	8 136	9 854	5 488	6 773	10 298	3 525	52
Импорт	5 235	6 766	8 622	5 045	6 310	6 923	613	10
<b>2. Үйлчилгээ</b>	<b>-1 450</b>	<b>-1 675</b>	<b>-2 355</b>	<b>-1 224</b>	<b>-1 538</b>	<b>-1 871</b>	<b>- 333</b>	<b>22</b>
Экспорт	655	814	1 135	550	815	1 371	557	68
Импорт	2 105	2 490	3 490	1 774	2 353	3 243	890	38
<b>Тээвэр</b>	<b>- 212</b>	<b>- 167</b>	<b>- 763</b>	<b>- 133</b>	<b>- 509</b>	<b>- 584</b>	<b>- 75</b>	<b>15</b>
Экспорт	384	569	596	379	405	662	257	64
Импорт	596	735	1 359	512	914	1 246	332	36
<b>Аялал</b>	<b>- 521</b>	<b>- 722</b>	<b>- 745</b>	<b>- 601</b>	<b>- 531</b>	<b>- 493</b>	<b>38</b>	<b>- 7</b>
Экспорт	29	21	251	14	195	458	263	2 <sup>1</sup>
Импорт	550	742	996	615	725	951	225	31
<b>Бусад үйлчилгээ</b>	<b>- 718</b>	<b>- 787</b>	<b>- 847</b>	<b>- 490</b>	<b>- 498</b>	<b>- 794</b>	<b>- 296</b>	<b>59</b>
Экспорт	242	225	288	156	215	252	37	17
Импорт	959	1 012	1 135	647	714	1 046	333	47
<b>3. Анхдагч орлого</b>	<b>-1 253</b>	<b>-2 232</b>	<b>-1 615</b>	<b>-1 498</b>	<b>-1 098</b>	<b>-1 235</b>	<b>- 137</b>	<b>12</b>
Экспорт	341	292	344	220	246	332	86	35
Импорт	1 595	2 524	1 959	1 718	1 344	1 567	223	17
<b>4. Хоёрдогч орлого</b>	<b>273</b>	<b>429</b>	<b>434</b>	<b>373</b>	<b>384</b>	<b>339</b>	<b>- 45</b>	<b>- 12</b>
Экспорт	371	511	508	434	439	397	- 41	- 9
Импорт	98	82	74	61	55	59	4	7


<sup>1</sup> дахин их

Үйлчилгээний орлого 2023 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 556.6 сая ам.доллороор өсөхөд тээврийн үйлчилгээнийх 257.0 сая ам.доллороор, аяллын үйлчилгээнийх 263.0 сая ам.доллороор, бусад үйлчилгээнийх 36.6 сая ам.доллороор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Харин үйлчилгээний зардал 2023 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 889.9 сая ам.доллороор өсөхөд тээврийн үйлчилгээнийх 331.6 сая ам.доллороор, аяллын үйлчилгээнийх 225.4 сая ам.доллороор, бусад үйлчилгээнийх 332.9 сая ам.доллороор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Үйлчилгээний орлогын 48 хувийг тээврийн үйлчилгээ, 33 хувийн аялал жуулчлалын үйлчилгээ, 19 хувийг бусад үйлчилгээний орлого тус тус эзэлж байна. Харин үйлчилгээний зардлын 39 хувийг тээврийн үйлчилгээ, 29 хувийн аялал жуулчлалын үйлчилгээ, 32 хувийг бусад үйлчилгээний зардал тус тус эзэлж байна.

## ЗУРАГ 2. УРСГАЛ ДАНС, жил бүрийн эхний 9 сард, сая ам.доллар



Хөрөнгийн данс 2023 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 92.8 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 12.7 сая америк доллароор өсжээ.

## ХҮСНЭГТ 3. САНХҮҮГИЙН ДАНС, сая америк доллар

	Жил			Эхний 9 сар			Өөрчлөлт	
	2020	2021	2022	2021	2022	2023	Дүн	Хувь
<b>САНХҮҮГИЙН ДАНС</b>	<b>-1 504</b>	<b>-1 982</b>	<b>-1 644</b>	<b>-1 001</b>	<b>- 906</b>	<b>- 461</b>	<b>445</b>	<b>- 49</b>
<b>ГШХО</b>	<b>-1 693</b>	<b>-2 060</b>	<b>-2 428</b>	<b>-1 453</b>	<b>-1 028</b>	<b>- 956</b>	<b>72</b>	<b>- 7</b>
Актив	26	113	76	102	56	30	- 26	- 47
Пассив	1 719	2 173	2 504	1 555	1 084	986	- 98	- 9
<b>Багцын хөрөнгө оруулалт"</b>	<b>563</b>	<b>25</b>	<b>445</b>	<b>35</b>	<b>187</b>	<b>182</b>	<b>- 5</b>	<b>- 3</b>
Актив	43	59	96	44	75	79	4	5
Пассив	- 520	34	- 349	10	- 112	- 102	9	- 8
<b>Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд</b>	<b>- 6</b>	<b>- 8</b>	<b>- 11</b>	<b>- 4</b>	<b>- 11</b>		<b>11</b>	<b>-</b>
Актив	- 6	- 7	- 11	- 4	- 11		11	-
Пассив			1					-
<b>Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>- 369</b>	<b>60</b>	<b>351</b>	<b>421</b>	<b>- 54</b>	<b>313</b>	<b>368</b>	<b>-</b>
Актив	484	210	226	224	254	304	50	19
Бэлэн мөнгө ба харилцах	321	84	267	111	245	225	- 20	- 8
Зээл	- 6	75	- 14	76	- 8	20	28	-
Худалдааны зээл ба урьдчилгаа	170	51	- 27	37	17	59	41	2 <sup>1</sup>
Пассив	853	149	- 125	- 197	309	- 9	- 318	-
Бэлэн мөнгө ба харилцах	42	- 161	- 32	- 25	- 36	- 9	27	- 74
Зээл	797	575	- 81	135	206	397	191	93
Худалдааны зээл ба урьдчилгаа	13	- 362	- 12	- 404	139	- 397	536	-

<sup>1</sup> дахин их

Санхүүгийн дансны тэнцэл 2023 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 460.8 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс ашиг 445.2 сая ам. доллароор буурчээ.

Санхүүгийн дансны ашиг буурахад Бусад хөрөнгө оруулалтын дансны пассив дахь Худалдааны зээл ба урьдчилгаа буюу харьяат бусад төлсөн төлбөр 396.6 сая ам.доллар болсон нь голлон нөлөөлжээ.

Төлбөрийн тэнцэл 2022 эхний 9 сард 1.4 тэрбум ам.долларын алдагдалтай байсан бол 2023 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 791.4 сая ам.долларын ашигтай гарсан байна.

### **Ойлголт, тодорхойлолт:**

**Төлбөрийн тэнцэл:** Тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг нэгтгэсэн статистикийн тайлан бөгөөд дараах 3 бүлгээр нэгтгэн боловсруулдаг.

**Урсгал данс:** Эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ.

**Хөрөнгийн данс:** Хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

**Санхүүгийн данс:** Монгол Улсаас бусад гадаад улсад хийсэн хөрөнгө оруулалт/актив/, бусад улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалтын/пассив/ гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна. Санхүүгийн дансанд активын өсөлт пассивынхаас илүү, активын бууралт пассивынхаас бага эсвэл актив өсөж, пассив буурсан үед "+" буюу алдагдалтайг, эсрэгээр пассивын өсөлт активынхаас илүү, активын бууралт пассивынхаас илүү эсвэл актив буурч, пассив өссөн үед "-" буюу ашигтайг илэрхийлнэ.

**Цэвэр нөөц:** Гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын Сангийн зээлийн үлдэгдэл болон богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг ойлгоно.

**Шууд хөрөнгө оруулалт:** Харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар, харьяа нэгжийг байгуулах үйл ажиллагааг ойлгоно.



### **Эх үүсвэр:**

Монголбанк

### **Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.1212.mn/>

### **Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2023 оны 11 дүгээр сарын 15.

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга М.Оюунжаргал  
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
Мөнгө, санхүү, үйлчилгээний хэлтсийн  
Ахлах статистикч Д.Буманбаяр  
Утас : (976-11)-326414



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212